

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244813

МОДОН ЦУУР УРЛАЛЫН АСУУДАЛД

П.Даваапил
Б.Баяннамсрай

Хураангуй: Модон цуурын гарал үүсэл, хөг тогтолцоо, урын сан, хийц бүтцийн талаас нь судалсан судалгааны ажлууд цөөнгүй байна. Эдгээр ажлуудад модон цуурыг өвлөн уламжилж ирсэн өвлөн уламжлагчдын цуур урлах арга барил, материалыг дэлгэрэнгүй өгүүлсэн байна. Тэд эхэн үедээ өөрсдийн амьдардаг газар оронд түгээмэл ургадаг гишүүнэ, цооргоно, балчиргана зэрэг гол нь хөндий модлог ургамлыг ашиглан цуур урладаг байсан авч тэр нь амархан эвдэрдэг, хэврэг байжээ. Тиймээс илүү хатуу, гол нь хөндий бус хуш, нарс, хар модны голыг хөндийлж ухан буцааж эвлүүлж наах, утсаар ороох, малын өлөн гэдсээр бүрэх зэргээр бат бөх болгожээ. Үүний зэрэгцээ модон цуурын гурван нүхийг гаргахдаа цуурын доод талаас нь тухайн цуур урлаач өөрийн хуруугаараа хэмждэг байсан нь цуурын нүх хоорондын зай өөр өөр болоход нөлөөлсөн байна. Мөн цуурын урт, дээд амсар, доод амсрын нүхний голч нь өөр өөр байна. Энэ нь цуурчид хамтран цуурдах, өөр бусад хөгжмийн зэмсэгтэй хамсрах, найрал хөгжмийн бүрэлдэхүүнд оруулахад бэрхшээл учруулж байна. Иймээс бид энэхүү өгүүлэлдээ модон цуур урлал, түүний хөг тогтолцоонд тулгарч буй асуудлыг судаллаа. Ингэхдээ цуур урлаачдын цуур урлах арга барилыг харьцуулан судалж өөрсдийн санал, дүгнэлтээ дэвшүүлээ.

Түлхүүр үг: Цуур, модон цуур, цуур урлал, хөг, гишүүнэ, балчиргана, залаат, хар мод

Оршил

Модон цуурын гарал үүслийн тухайд түүхчид, соёл урлаг судлаачид эртний түүхийн сурвалж бичгүүд, археологийн дурсгал, аман мэдээ, өвлөн уламжлагч нарын ярианд тулгуурлан өөр өөрсдийн санал, таамаглалыг дэвшүүлсэн байна. Эндээс үзвэл модон цуур нь Хүннүгийн үед лавтай хэрэглэгдэж байсан Монголчуудын язгуур хөгжмийн зэмсгийн нэг болох нь тодорхой байна. Харин урлал, хөг тогтолцооны талаар Ж.Бадраа, Ж.Энэбиш, Ф.Мэргэжих, С.Баянжаргал, Э.Жиндалай, Г.Нямжанцан, Н.Санжаадорж тэргүүтэй судлаачид, цуурчид өөрсдийн судалгааны бүтээлдээ өгүүлжээ. Гэвч эдгээрийг харьцуулан үзсэн, цуур урлалд тулгамдаж буй асуудлыг хөндсөн судалгааны ажил хараахан гараагүй байна. Тиймээс бид энэхүү өгүүлэлдээ цуур урлалд тулгамдаж буй асуудлыг хөндөхийг зорьлоо.

Үндсэн хэсэг

Цуур урлаачид модон цуурыг юугаар, хэрхэн урладаг байсныг сийрүүлъя. Цуурыг гишүүнэ¹, балчиргана², залаат³, хар мод⁴ зэрэг модлог үет ургамлын гуурс ишээр хийдэг. Энэ нь цуур урлах энгийн, эртний арга бөгөөд эзгүй хээр яваа анчин, малаа хариулж буй малчин, хэн боловч цуурыг хоромхон зуур түвэггүй урлах боломжтой байсныг илтгэдэг. Модон цуур урлах үндсэн материал нь байгалийн бэлэн ургамал, төрөл бүрийн мод болон малын гаралтай түүхий эд юм. Тиймээс бид дараах хүснэгтэд эдгээр модны бүтэц, онцлог, тархцыг харуулъя.

Ургамлын нэр	Онцлог	Хэлбэр	Ургадаг газар, орон
Гишүүнэ	Олон үетэй	Конус хэлбэртэй	Монгол орны ой хээр, тал, хангайн бүсэд тархсан
Балчиргана	Гишүүнийг бодвол дуу сайтай, үе багатай, арай бүдүүвтэр хэмжээтэй.	Голдоо хөндий	Алтайн ууланд асгатай газар ургадаг
Залаат	Гишүүнэ, балчиргана хоёрыг бодвол арай нарийн	Голдоо хөндий	Зөвхөн уулархаг, хангайн нутгаар ургадаг
Хуш	Шилмүүс нь зөөлөн бараандуу ногоон өнгөтэй	Конус хэлбэртэй	Уулархаг хангайн нутгаар ургадаг
Нарс	Зөөлөн ширхэгтэй	Конус хэлбэртэй	Дэлхийн бөмбөрцгийн хойд хэсгээс гаралтай.
Хус	Цагаан өнгөтэй, нарийн болоод чийрэг	Конус хэлбэртэй	Монгол орны ой хээр, тал, хангайн бүсэд тархсан
Хулс	Нягт, бах бөх чанартай	Иш нь бөөрөнхий, үе үеэр ургадаг, дотроо хөндий	Халуун бүс нутгаас гаралтай
Шинэс	Жавартай сэрүүн орчинд маш тэсвэртэй	Конус хэлбэртэй	Ой тайгад ихээр ургадаг
Хар мод	Бусад ургамалыг бодвол хатуу	Конус хэлбэртэй	Ойт хээр, хангайн бүс нутагт ургадаг

Хүснэгт-1. Цуур урлалд хэрэглэж буй мод, модлог ургамлын онцлог, тархац

¹ Олон үетэй, конус хэлбэртэй, гол нь хөндий, манай оронд элбэг ургадаг ургамал юм.

² Алтайн ууланд асгатай газар ургадаг, гол нь хөндий, гишүүнийг бодвол дуу сайтай, үе багатай, арай бүдүүвтэр хэмжээтэй.

³ Гишүүнэ, балчиргана хоёроос арай нарийн, зөвхөн уулархаг, хангайн нутгаар ургадаг. Залаатаар хийсэн цуурыг Шинжианы Хандгайт, ханас, зэрэг газрын урианхай, тува цуурчид хэрэглэдэг байна.

⁴ Бусад ургамалуудыг бодвол арай хатуу, конус хэлбэртэй, тархацийн хувьд хаа сайгүй ургадаг.

Байгалийн бэлэн материалыг ашиглан цуур урлах нь хялбар боловч эдлэхэд хэврэг байжээ. Иймээс цуурыг эдэлгээ сайтай, бат бөх болгох нийгмийн шаардлага аяндаа гарч ирсэн байна. “Эдүгээ цуурыг урлахад хангайн хар мод юм уу цагаан бургас, нарс⁵-ыг ширхгийн дагуу цуулж, хоёр хэсэг болгоод, хэсэг тус бүрийн голоор ховил гаргаж, түүнийгээ хавсарган нааж гуурс болгоод, завсар зай гаргахгүйн тулд гадуур нь хонины улаан хоолойн хальсыг битүү углах зэрэг нарийн чимхлүүр арга технологи хэрэглэх болсон нь цуур урлах технологийн өөрчлөлт хөгжлийг илтгэж байна” (Модон цуур I, 2015:19).

ХБК-ийн багш, цуурч, цуур урлаач Г.Нямжанцантай цуур урлах арга технологийн талаар ярилцахад “Ихэвчлэн хуш⁶ модоор хийдэг хуш модны хатуу зөөлөн байдал нь цуурт их тохиромжтой санагддаг. Мөн хар модоор хийх тохиолдол бас байдаг. Цуурыг урлахдаа модоо цуулж голыг нь ухаж ховил гаргаад цуулсан хоёр модоо эвээр нь наагаад гадна талаар нь өлөн ороож бэхэлнэ. Өлөн маань тухайн модыг хий алдах боломжгүй болтол хатаачихдаг. Хэрвээ хий алдсан тохиолдолд уг хөгжим маань дуугарахгүй байдаг онцлогтой учраас хий алдалтаас хамгаалаад хонины улаан хоолойн дотор талын нимгэн хальс юм уу өлөнгөөр гадуур нь ороож хэрэглэдэг уламжлалыг ашигладаг. Цуурыг хар модоор урлахад цангинасан, цацарсан дуутай цуур болдог харин хуш, нарсаар урласан тохиолдолд жоохон бөглүүдүү дуутай болдог” хэмээсэн юм. Энд цуур урлаж буй модны бүтэц, ширхэг, хатуу зөөлнөөс хамаараад дуу, тембр⁷ нь өөр өөр болдог гэдгийг дурдсан нь онцлууштай байна.

Урианхай модон цуурын хийц нь эртний Монголчуудын амьдрал ахуйтай зохицсон хөгжим урлах өндөр мэргэжлийн ур чадварын шинжийг хадгалсан байдаг. Урианхай цуурыг голдуу улаан харгай модоор хийдэг. Зарим газарт бургас, хар мод, шар мод, хус⁸, залаат зэрэг мод ургамлаар хийдэг болох нь судлаачдын бүтээлээс тодорхой харагдаж байна. “Шилж тохирсон материалаа дээд үзүүрээс доод үзүүр хүртэл нарийсган бөөрөнхий зоргож, голоор нь шулуун зүсэж ангилан, голыг нь ухаж хөндийлөөд, хоёр хэсэг ухаж нимгэлсэн модоо “Зус”⁹ цавуугаар дахин хэвд нь наалдуулж, хонь малын улаан хоолойн нимгэн цагаан хальсыг авч цуурын гадуур углан, мяндсан утсаар ороон бөхөлж хатаадаг” (Жиндалай, 2012: 36-38) болохыг Э.Жиндалай тэмдэглэсэн байна.

Мөн Ховд аймгийн Дуут сумын н.Баатаржав хатуу хуш модоор нүх гаргаж урианхай цуурыг урладаг юм. Урианхай Балдан дунд зэргийн хатуу хоёр хэсэг

⁵ Конус хэлбэртэй, дэлхийн бөмбөрцөгийн хойд хэсгээс гаралтай.

⁶ Шилмүүс нь зөөлөн бараандуу ногоон өнгөтэй, конус хэлбэртэй, уулархаг хангайн нутгаар ургадаг.

⁷ Н.Жанцанноров 1996 онд хэвлүүлсэн “Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь” бүтээлийнхээ 95-р талд тембр буюу эгшиглэгээг 1. Хөгжмийн эгшгийн шол шинж тэмдэг /бүдүүн, өндөр, нам, чанга, сул, урт, богинын нэг адил/. Эгшиглэгээ нь нэг эгшигийг өөр өөр хөгжмийн зэмсгээр, өөр өөр арга маягаар, өөр өөр хоолойгоор хөгжимдөх, дуулахад ялгарах шинж. Эгшиглэгээ эгшиг гаргах эд ангиас онцгой хамаарна. Мод, төмөр, хялгасаар үйлдсэн хөгжмийн зэмсгийн эх бие, чавхдас нэг ижил эгшигийг өөр өөр өнгөөр гаргана. Энэ нь эгшиглэгээ юм. 2. Хөгжмийн гоо зүйн нэг ойлголт гэжээ.

⁸ Цагаан өнгөтэй, нарийн болоод чийрэг, конус хэлбэртэй.

⁹ Загас, үхэр малын арьс ширийг чанан өтгөрүүлж хийсэн цавуу.

модыг авч хооронд нь цавуудан нийлүүлэн хийдэг. Энэ бол цуур хийдэг Урианхай аргын хоёр жишээ юм. Ховд аймгийн Ховд хотын н.Балдандорж нь хавтгай дугуй цуур хийдэг. Хоёр хэсэг модыг авч урлаад цавуудаж залгадаг. Модон биеийг сийлж үрж зүлгээд нягт залгаж хийдэг. Тэгээд нимгэн лакдаж хар утсаар ёроолыг хүртэл ороож дээд талыг бэхэлдэг. Үлээдэг нүх бага зэрэг өргөн байдаг. Цуурын нүхийг ухаж гаргаж, сийлээд түлдэг. Хулс мод¹⁰, шинэс¹¹, нарс модыг ашиглаж хийсэн цуур зохиогчийн цуглуулгад байдаг байна. (Жиндалай, 2012: 129) Эндээс бид хийдэг мод, ургамал цавуу нь нутаг нутагт өөр өөр байгааг харж болно. Учир нь бидний өмнө авсан баримтуудад буйгаас энд буй мэдээ багагүй ялгаа зөрөөтэй байна.

Ф.Мэргэжих, С.Баянжаргал нарын судалгаанд Тавинтай гуай хэрхэн цуур урладаг болохыг тэмдэглэсэн байна. Тэд “Цуурын хийцийн тухай Тавинтай гуай хэлэхдээ цуурыг улаан харгайгаар сөөмлөж хийгээд хонины улаан хоолойн цагаан хальсаар бүрдэг байна” гэжээ. Ингэхлээр эхэн үедээ бэлэн нүхтэй мод, ургамлыг ашигладаг байснаа яваандаа хатуу модлог ургамал, төрөл бүрийн модыг ашиглан урладаг болсон нь цуур урлах арга технологи бий болсныг гэрчилж байна. Хойд Шинжаань нутагт модноос нимгэн хатуу хулс элбэг бөгөөд улиангар модыг цуур хийхэд хэрэглэдэг. Шинэсийг бол байнга ашигладаг. Хатуу модыг бол сийлбэртэй цуур хийхэд ашигладаг байна. Өөрөөр хэлбэл дээрх мэдээ баримтуудад нарс, хус, хуш, харгай, хар мод, шинэс, улиангар гэх мэт төрөл бүрийн мод, модлог ургамлуудаар хийж болно гэдгийг цуур урлаачид болон судлаачид тэмдэглэсэн байна.

Мөн зарим эх сурвалжуудад модон цууртай “Ху Жиа”-г холбоотой хэмээн тэмдэглэсэн байдаг. Тэгвэл Ху Жиа-гийн хийц материалын тухай “Дундад улсын нэвтэрхий их тольд”-д тэмдэглэсэн нь “Гуурсыг үлээж дуугаргах хөгжмийн зэмсэг, Хятадын эртний үлээвэр хөгжим, бас Ху Жиа гэдэг. Хан улсын үед Хүннүгийн газраас уламжлан оров, нэгтгэх хэллэг нь Лү Бүө Ян дайны үймээнээс оргож баруун Рүн улсад байхдаа зохиов. Анхандаа зэгсний навчаар хуйлан хийдэг, сүүлээр нь зэгсний навчаар шүглүүр, бурзан хийж, зэгсний иш буюу хонь ямааны ясаар хонгио хийдэг болсон, ихэнхдээ даралтын нүхгүй байдаг” (Жиндалай, 2012: 33) хэмээн Э.Жиндалай тэмдэглэжээ.

Ж.Бадраа “Цуурыг голдуу модоор хийдэг учраас модон цуур гэсэн бололтой. Гэвч хэлбэр, хэмжээ нь өөрчлөгдсөөр иржээ. Жишээ нь: бугалга буюу доод амсар нь эртгэр, гансны толгой шиг, дундаа модтой хоёр талдаа эвэрлэсэн, одоогийнхоос арай урт цуур ч байсан байна. Одоо баруун монгол ардын дунд хэрэглэдэг цуур бол бургас буюу хар модыг ухаж эв нийлүүлэн хийгээд бог малын улаан хоолойгоор бүрж утсаар ороон, зарим үес доллардон өнгөлдөг, гурван нүхтэй цуур байгаа” (Бадраа, 1998: 49) гэж бичжээ. Энд цуур урлах арга нэлээд төгөлдөржин басхүү өдгөө хэрхэн урлаж байгааг тодорхой өгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл цуур урлаачид орчин цагт бат бөх байх үүднээс голдуу хар модоор урлаж бог малын өлөн гэдсээр ороож бэхжүүлж байна. Ийнхүү цуур

¹⁰ Иш нь бөөрөнхий, үе үеэр ургадаг, дотроо хөндий, Ази тивийн халуун бүс нутгаас гаралтай.

¹¹ Жавартай сэрүүн орчинд маш тэсвэртэй, конус хэлбэртэй, ой тайгад ихээр ургадаг.

урлахад хийх материалыг урьдчилан нарийн технологийн дагуу бэлтгэх хэрэгтэй юм. Ялангуяа модны хатаалгад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Энэ нь цуурыг бат бөх байлгаад зогсохгүй зөв хөгтэй, сайхан дуутай болоход ч чухал нөлөөтэй юм.

Тэгвэл цуур урлах модыг хэрхэн хатаадаг болохыг судалбал “Цуур урлах модоо бэлтгэхдээ тухайн модныхоо амин чийгийг удаан хугацааны турш сэрүүн газар байлган хатаах хэрэгтэй байдаг байна” (Хэрлэн, 2009: 102) гэжээ. Ингэж хатаасан мод нь цуурдах явцад байнга усан чийглэхэд усанд дэвтдэггүй сайн талтай ажээ. Ингээд “Хатаасан модноосоо 3 төөг таслан авч конус хэлбэртэйгээр бөөрөнхийлөн харуулдана. Түүний дараа модоо голоор нь хоёр хэсэг болгож цуулан доторх хэсгийг нь ухааж аваад эргээд хоёр хэсгээ эвээр нийлүүлэн барьцалдуулж наана. Дараа нь уг модоо нарийн утсаар хөдөлгөөнгүй болгон чанга баглаад бог малын хатаасан өлөн гэдсийг усанд дэвтээгээд, багласан модоо өлөндөө шургуулж, хий агаар алдахгүй болгож сүүдэр газар хатаана. Эцэст нь бэлэн болсон их биедээ эгшиглэгээг үүсгэх даралт нүхнүүдийг гаргана” (Хэрлэн, 2009: 102-103) хэмээсэн байна. Хий гаргахгүй байх, өлөнгөөр нягт сайн ороож баглах нь сайхан дуутай болгохын хамт цуурыг дуугаргах, үлээж сурахад хялбар болгоно. Энд хүртэлх цуур урлах арга ажиллагаа, уламжлал нь ерөнхийдөө нийтлэг байна. Харин үүнээс хойших ажилбарууд нь хувь урлаач, газар орон, цаг хугацаанаас хамааран өөр өөр байна.

Өөрөөр хэлбэл “Ардын хөгжмийн дадал туршлагаас үзэхэд цуурын нүхийг цуурын үзүүр талаас эхэлж хэмждэг байв. Нүхний хоорондох зайг хэмжих хэмжүүр нь цуурчийн гарын хуруу юм. Эхний нүхийг 4 хуруу, дараагийн нүхийг түрүүчийнхээс 3 хуруу, сүүлчийн нүхийг 4,5 хуруу зайд тус тус гаргана” (Энэбиш, 2007: 415) гэсэн байхад Л.Хэрлэн “Нүхийг гаргахдаа үзүүрийн нарийн хэсгээс нь 5 хуруу зайнд нэг даралт нүхийг, түүнээсээ 3 хуруу зайнд 2 дахь нүхийг, хамгийн сүүлийн нүхийг 5 хуруу зайнд нүхэлнэ. Даралт нүхийг гаргахдаа ямар нэгэн зүйлээр зорохгүйгээр зөвхөн төмөр улайсгаж цоолж бэлэн болгоно. Ингэснээр цуур хөгжим нь бэлэн болно” (Хэрлэн, 2009: 103) хэмээсэн байна.

Ф.Мэргэжих нарын “Монгол дуу хөгжмийн судлал” номд үзүүлсэн Тавинтай гуайн цуурын нийт урт нь 60 см, доод амсраас нэгдүгээр нүх хүртэлх зай 7,2 см, нэгдүгээр нүхнээс хоёрдугаар нүх хүртэлх зай 7,4, хоёрдугаар нүхнээс гуравдугаар нүх хүртэлх зай 8 см гэж тэмдэглэгдсэн бол Манидар гуайн урласан цуурын нийт урт 57,5 см, доод үзүүрээс эхний нүх хүртэл 10см, эхний нүхнээс хоёрдугаар нүх хүртэл 6,5 см, хоёрдугаар нүхнээс гуравдугаар нүх хүртэл 10 см” (Мэргэших., Баянжаргал, 1997: 162-163) гэж тэмдэглэгдсэн байна. Эндээс цуур урлаачдын цуур хөгжим урлах хэмжээ нь өөр өөр байгаа гэдэг нь нотлогдож байна.

Манидар¹² цуурчийн цуурын нүх хоорондын зайг С.Баянжаргал 1986 онд надад өөрийнхөө хэрэглэж байсан цуурыг дурсгаж өгсөн билээ гээд “Түүний цуурын урт нь 53 см, үлээх талаас цуурын зав талын 1-р нүх хүртэл 27,7 см, 2-р нүх хүртэл 37,7 см, 3-р нүх хүртэл 43,7 см болох бөгөөд үлээх талын нүхний

¹² Манидар эрэгтэй 75 настай. Алтай хотын Хандгайтын Ах сумын хүн.

диаметр нь 1,5 см болно. Эдгээр бодит тооноос үзэхэд нэгдүгээр ба хоёрдугаар нүхний хоорондох зай нь 10 см, хоёрдугаар ба гуравдугаар нүхний хоорондох зай нь 6 см. Цуурч Манидар дээрх аязуудыг малын улаан хоолойн дотор биеийн нимгэн цагаан хальсаар бүрсэн модон цуураараа татсан билээ (Мэргэжих., Баянжаргал, 1997: 243) гэж тэмдэглэжээ.

Г.Нямжанцан “Доод амсраас нь эхлээд 4 хуруу зайтай эхний нүхийг дараа нь эхний нүхнээс 3 хуруу тавиад хоёр дахь нүхийг, дараа дахиад 4 хуруу тавиад 3 дахь нүхийг цоолдог. Нүхийг цоолохдоо мөлхөж яваа хүүхдийн чигчий хурууны хумсны толионы хэмжээтэй байхаар бодож цоолно. Харин дээд амсрын гол нь ойролцоогоор 21 мм, доод амсрын голч 12мм байхаар урладаг. Ая данг нь тааруулсан байх хэрэгтэй учраас нүхнүүдийг хийхэд зарим тохиолдолд нэг нүх нь өнгө нь жаахан дээрдвэл дараагийн нүхний өнгийг жаахан доошлуулж хийх гэх мэт хэмжээг үндэслэл болгож хөгжмөө урладаг. Мөн орчин цагийн хэрэглээгээ дагаад өнгө үзэмжид нь анхаарч гадна талаас нь сураар боох, дээд болон доод хэсгийг нь илүү хатуу модоор углуургадаж хийдэг” (Г.Нямжанцантай хийсэн ярилцлага. 2016.11.14) гэж ярьсан юм.

С.Юндэнбат “Урианхай цуур гурван даралттай. Цуурын нэг үзүүрээс 4 хуруу зайд баруун гарын долоовор хуруугаар дарах зориулалттай анхны нүхийг, түүнээс 3 хуруу зайд баруун гарын эрхий хуруугаар дарах хоёр дахь нүхийг, түүнээс дахин 4 хуруу зайд зүүн гарын долоовор хуруугаар дарах 3 дахь нүхийг тус тус цоолно. Түүнээс нэг төө, мухар сөөм хэмжээд цуурын үлээх үзүүр буюу амгайг гаргана. Цоолох нүхний хэмжээ нь мөлхөж байгаа балчир хүүхдийн гарын хурууны хумсны толионы хир байна” (ЦУУӨБТА, 2015: 9) гэж тэмдэглэжээ.

Энэ мэт судлаачдын мэдээнээс гадна хэн, хэзээ хэрэглэж байсан нь үл мэдэгдэх цууруудыг Н.Санжаадорж олж илрүүлэн хэмжилт хийжээ. Тухайлбал, Үндэсний түүхийн музейд хадгалагдаж буй Баян-Өлгий аймгийн н.Төмөрөөс 1984 онд авсан нарийн мяндсан утсаар ороож бог малын өлөнгөөр бүрсэн бургасан цуурын нийт урт нь 60см, дээд амсрын нүхний тойргийн хэмжээ 1,3см, доод үзүүрийн амсрын тойрог 0.6 мм, доод үзүүрээс 1-р нүх 9,5 см, 1-р нүхнээс 2-р нүх хооронд 5,6 см, 2-р нүхнээс 3-р нүх хооронд 9см байна. Мөн хэзээ хийсэн, хэн хэрэглэж байсан нь тодорхойгүй, цуглуулгаар олдсон голдоо хөндий 2 хэсэг хар модыг нийлүүлж нарийн сураар ороож, бог малын өлөн шургуулж хийсэн цуурын нийт урт нь 68 см, дээд амсрын нүхний тойргийн хэмжээ 1,4 см, доод үзүүрийн амсрын тойрог 0,7 мм, доод үзүүрээс 1-р нүх 10,5 см, 1-р нүхнээс 2-р нүх хооронд 6 см, 2-р нүхнээс 3-р нүх хооронд 12 см байсан байна. Мөн цуурыг тоглоочийн амьсгааны багтаамжаас шалтгаалан урт, богино янз бүрийн хэмжээтэй /ихэнхдээ 54-62см байна/ урладаг (Модон цуур I, 2015: 29). Эндээс дүгнэвэл цуурын нүх гаргах хэмжээ харилцан адилгүй байхын зэрэгцээ хэтэрхий тойм байна. Тодруулбал, хуруу хэмээх нь том хүний хуруу юм уу, хүүхдийн хуруу юм уу, өөрийнх нь хуруу юм уу гэх мэтчилэн тодорхойгүй байгаа нь өөр өөр урлаачийн урласан цуурын хөг хоорондоо тохирох эсэх эргэлзээг төрүүлж байна.

Эдгээр нүхнүүдийг гаргах болон хоорондын зайг тогтоох нь модон цуур урлах үйл ажиллагааны хамгийн чухал хэсэг юм. Нүх хоорондын зай, голчийн

зэрэгцээ урт нь ч мөн цуурын хөгийг тохируулахад чухал үүрэгтэй. Тиймээс одоо цуурын уртыг хэрхэн тодорхойлсныг судалбал Ж.Энэбиш “Энэ нь угтаа дээд хэсэг нь арай бүдүүн, үзүүр тийшээгээ нарийвтар 3 см-ийн голчтой, 58-60 см-ийн урттай, голыг нь хөндийлж ухаж нимгэлсэн шулуун урт мод юм” (Энэбиш, 2007: 415) хэмээсэн байна. Н.Санжаадорж “Эртний цуурын уртыг хоёр тохой (нэг тохой нь 40-45см) дөрвөн ямх (нэг ямх нь 3,2см) буюу нэг метр гарантаа (105см) гэж тодорхойлсон” (Санжаадорж, 2015: 25) байна. Г.Нямжанцан “Хөгтэй хийхийн тулд уламжлагдаж ирсэн аман хэмжээний дагуу нийт урт нь 3 төө гарантаа буюу 64см орчим” гэсэн бол Л.Хэрлэн “Монгол ардын хөгжмийн зэмсгийн түүхээс” номдоо модон цуур хөгжмийн уртыг “3 төө хэмээжээ.

Мөн “Урианхайчуудын модон цуурын уртын хэмжээ нь гурван төө хоёр хуруугаас гурван төө дөрвөн хуруу хавьцаа урттай бөгөөд, барагцаагаар 54-60см-ийн хооронд байдаг. Доод хэсэгтээ гурван даралтын нүх нүхэлдэг, доод амсраас дээш дөрвөн хурууны зайд нэгдүгээр нүхийг нүхэлж, нэгдүгээр нүхнээс дээш гурван хурууны зайд хоёрдугаар нүх, түүнээс дээш дөрвөн хурууны зайд гуравдугаар нүхийг нүхэлдэг” (Жиндалай, 2012: 37) байхад “Шинжиан”-д илрүүлсэн модон цуурын бүх урт нь 58,5 см байжээ. Эндээс харахад цуурын тогтсон урт байхгүй байгаа бөгөөд баримжаа, барагцаа хэмжээ байхын хамт археологийн малтлагаар олдсон цуурыг хэмжсэн хэмжилт дээр үндэслэн урлаачид, судлаачид өөр өөр бичсэн нь тодорхой байна. Ийм нөхцөлд дээрх цуурууд жигдэлсэн хөггүй гэдэг нь илэрхий юм.

Дүгнэлт

Модон цуурыг ихэвчлэн хус, шинэс, хар мод, харгай тэргүүтэй мод, модлог ургамлуудаар урладаг бөгөөд эдгээр нь гол төлөв манай орны навчит модны дотроос хамгийн их тархацтай бөгөөд навч нь өргөн өндгөрхүү, сагсгар, өндөр ургадаг моднууд юм. Модон цуур урлахад тухайн урлалд ашиглах модыг зөв боловсруулах явдалд онцгой анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Учир нь модон цуур хийх материал болон модны хатаалгаас шалтгаалан цуурын өнгө, тембр тодорхойлогдож байна.

Модон цуур урлаачид уг хөгжмийн зэмсгээ урлахдаа түүний хэмжээ харьцаа, нүх хоорондын зай, дээд доод амсрын голчийг харилцан адилгүй сонгож байгаа нь өөр өөр хөг бүхий цуур бий болох үндэс болж байна. Мөн бидэнд уламжилж ирсэн модон цуурын хэмжээс хэт ерөнхий, тойм байгаа нь цуур урлал, хөг тогтолцооны нэгдсэн ойлголт бий болоогүйг илтгэж байна. Тиймээс модон цуур урлах нэгдсэн стандарт бий болгож, хөгийг нь жигдлэх нь уг хөгжимдүүрийг найрал хөгжмийн бүрэлдэхүүнд оруулж тоглох хийгээд бусад хөгжимдүүрүүдтэй хамсран тоглох зэрэг цаашдын хөгжилд нь чухал ач холбогдолтой юм.

Ном зүй

Бадраа, Ж. (1998). *Монгол ардын хөгжим*. Улаанбаатар: T&U Printing Co., Ltd
Жанцанноров, Н. (1996). *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь*. Улаанбаатар:
Жиндалай, Э. (2012). *Модон цуурын судалгааны тойм*. Улаанбаатар: Урлаг судлалын ухааны
магистрын зэрэг горилсон бүтээл.
Монгол цуур I. (2015). Улаанбаатар:

- Мэргэжих, Ф., Баянжаргал, С. (1997). *Монгол дуу хөгжмийн судлал*. Шинжианы ардын хэвлэлийн хороо.
- Санжаадорж, Н. (2015). *Цуурын хийц бүтээлийн харьцуулсан судалгаа*. Улаанбаатар: Урлаг судлалын ухааны магистрын зэрэг горилсон бүтээл.
- Хэрлэн, Л. (2009). *Монгол ардын хөгжмийн зэмсгийн түүхээс*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Цуурын уламжлалт урлагийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд [ЦУУӨБТА].* (2015). ЭШХ-ын илтгэлийн эмхэтгэл.
- Энэбиш, Ж. (2007). “Хүннү”-гийн модон цуур. Уран сайхны шүүмж буюу онгодыг өдөөгч халгай 413-423. Арвай принт хэвлэлийн газар.
- Г.Нямжанцантай хийсэн ярилцлага*. Хөгжим бүжгийн коллеж 2016.11.24.

Summary

Much research has been done on the origin, tonal system, repertoire, and structure of the wooden “Tsuur”. In these works, the method of crafting “Tsuur”, and the materials used are described in detail by the inheritors of wooden “Tsuur”. In the early times, they made “Tsuur” using mainly hollow-stemmed woody plants such as rhubarb, “tsoorgono”, and “balchirgana”, which were common in the area where they lived, but they were easily damaged and fragile. Therefore, they used more hard and monolithic trees, such as cedar, pine, and larch by hollowing them out and gluing them together. After that, they wrapped them with wire, and covered them with animal guts to make them strong. At the same time, the craftsman measured from the bottom of the “Tsuur” with his finger to make three holes in the wooden “Tsuur”, which caused the distance between the “Tsuur” holes to vary.

Also, the length of the “Tsuur” and the diameter of the upper and lower rim holes differ. It is difficult for musicians of “Tsuur” to play in an ensemble, combine with other instruments, and be included in an orchestra’s composition. Because of these reasons, in this article, we have studied the problems faced in wooden “Tsuur” crafts and its tonal system, compared with the different methods of “Tsuur” craftsmen, and put forward our opinions and conclusions.

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244814

МОНГОЛ ЯТГА БА ГОО ЗҮЙ: УЛАМЖЛАЛ БА ОРЧИН ҮЕИЙН
УЯЛДААН ДАХЬ УРЛАГИЙН ГОО САЙХАН

Ширчин

Хураангуй: Монгол ятга бол Монголын ард түмний төлөөлөл болсон уламжлалт хөгжмийн зэмсэг төдийгүй Монгол соёлын чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Түүнчлэн энэ нь орчин үеийн урлагийн салбарт тодорхой байр суурь эзэлж эхэлж байгаа юм. Энэхүү өгүүлэл нь Монгол ятгын гоо зүйн шинж чанар болон уламжлалт урлагийн уялдаан дахь илэрхийллийг судлав.

Ятгын түүхэн хөгжил, орчин үеийн урлагт хэрэглэгдэж буй байдал болон дэлхийн соёлын хэмжээнд гүйцэтгэж буй үүргийн талаар дүн шинжилгээ хийснээр энэхүү өгүүлэл нь ятгын урлагийн гоо зүйн гүн агуулга болон соёлын өв уламжлал, инновацын чухал нөлөөг гаргаж ирэх зорилготой юм. Энэ өгүүлэлд голчлон Монгол ятгын гоо зүйн онцлог шинж чанар болон хүмүүсийн ятгад татагдах дуртай байдлыг судалсан болно.

Түлхүүр үг: Монгол ятга, гоо зүй, уламжлалт урлаг, орчин үеийн урлаг, соёлын харилцаа, соёлын өв, хөгжмийн илэрхийлэл, урлагийн инновац

Оршил

Монгол ятга бол түүхэн хөгжлийн явцад бий болж, монгол соёлд гүн гүнзгий шингэсэн хөгжмийн зэмсэг бөгөөд орчин үеийн урлагт шинэ гэрэл гэгээ оруулж байна. Ятга хөгжим нь зөвхөн дууны илэрхийлэл төдийгүй өвөрмөц гоо зүйн шинж чанараараа дамжуулан соёлын гүн утга агуулга, сэтгэлийн нийцлийг илэрхийлдэг. “Хөгжим болон дүрслэх урлаг аль аль нь илэрхийллийн хувьд ялгаатай байдаг. Хөгжмийн онцлог нь илүү утгагүй, дуурайлгасан, дахин бүтээсэн байдалгүй гэдгээрээ тодорхойлогддог. Хөгжим нь бодит байдлыг дүрслэхгүй, харин хүний мэдрэмжээр дамжуулан илэрхийлдэг (Сүн Жин, 2004: 22). “Баруунд, хөгжмийн гоо зүйн боловсролын үзэл санаа нь эртний Грект эхэлсэн. Пифагор анх удаа хөгжмийн ‘цэвэрлэх’ нөлөөний талаар ярьж, үйлдэл, дуу хоолой нь сэтгэл хөдлөлийг илэрхийлж, эргээд сэтгэл хөдлөлийг өдөөж, хүний сэтгэлд нөлөөлдөг гэж үзсэн (Жун Зилин, 1999:296). Тиймээс Монгол ятга нь зөвхөн хөгжмийн үнэт зүйлээс гадна гоо зүйн боловсролоор дамжуулан хүний сэтгэлд эерэг нөлөө үзүүлдэг.

Энэ судалгаагаар Монгол ятгын гоо зүйн илэрхийллийг судлан, уламжлалт болон орчин үеийн урлагийн нэгдлийн гоо сайхныг тодорхойлно. “Хөгжим бол хүний сэтгэлийн илэрхийлэл, хүний өвөрмөц шинжийг ашиглан бүтээсэн соёлын

үзэгдлийн нэг юм (Энст Кассирер, 1985:89). Монгол ятга нь уламжлалт хөгжмийн зэмсэг бөгөөд түүний урлагийн илэрхийлэл нь зөвхөн хөгжмийн тэмдэглэлээр илэрхийлэгдэхээс төдийгүй хүний сэтгэл зүйн болон соёлын илэрхийлэл болдог. Монгол ятгын хөгжим нь хүний бие махбодын болон сэтгэлийн түвшинд хүрч, бүтээлч хүсэл болон соёлын ойлголтыг өдөөж чаддаг. “Кассирерийн тэмдэглэлийн шууд залгамжлагч, Америкийн орчин үеийн гоо зүй судлаач Сюзан Лангер нь зөвхөн Кассирерийн тэмдэглэлийн онолыг хүлээн авч, янз бүрийн тэмдэглэлийн арга хэлбэрийг тодорхойлсон (Сюзан Лангер, 1953:62). Монгол ятга нь өвөрмөц хөгжмийн илэрхийллээрээ зөвхөн сэтгэлийн илэрхийллийг дамжуулагч төдийгүй соёлын элементийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хүний сэтгэлийн нууц, соёлын гүн утга агуулгыг илэрхийлдэг.

Нэг. Монгол ятгын түүх ба хөгжил: Монгол ятга нь урт удаан түүхтэй бөгөөд Монголын уламжлалт урлагийн гол төлөөлөл болохыг дурдсан. Энэ хөгжмийн зэмсэг нь өвөрмөц дуу хоолой, тоглох нарийн техникээрээ алдартай бөгөөд соёлын өвийг хадгалах, уламжлалыг дамжуулахад чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Аристотелийн “урлагийн зорилго нь дотоод утгыг илэрхийлэх, гаднах хэлбэрийг бус” гэсэн үзэл баримтлал нь ятга урлагийн гүн гүнзгий утга агуулгыг тайлбарлахад тусалдаг. Ятга нь шашны ёслол, улс төрийн үйл ажиллагаа, ардын амьдралд хэрхэн хэрэглэгдэж, соёлын гүн нөлөөг дамжуулж байсныг харуулдаг. Монгол ятгын талаар олон түүх, гарал үүслийн домог байдаг.

Ятга нь албан ёсны ёслол, ард түмний баяр ёслол гэх мэт янз бүрийн баяр ёслолд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Эдгээр үйл ажиллагаанд ятга хөгжим нь хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, соёлын бахархлыг илэрхийлдэг. Тиймээс ятгыг судлах нь Монголын соёлын өвийг гүнзгий ойлгоход тусалдаг. Монгол ятга нь маш эртний хөгжлийн түүхтэй бөгөөд энэ талаар олон домог, түүх байдаг. Хамгийн алдартай нь Сайнхүүгийн ятгаар “буг чөтгөрийг” дарах тухай домог бөгөөд ард түмэнд аз жаргал, сайхан амьдралыг авчирсан гэж үздэг. Монгол ятга нь голчлон Монгол Улс болон Өвөр Монголын нутаг дэвсгэрт тархсан байдаг.

Түүхийн явцад монгол ятга анхдагч хэлбэрээ алдсан ч сүүлийн жилүүдэд Солонгосоос 1961онд Ким Зон Анийг (김정안) урьж, Наранбаатар багш зэрэг 16 оюутан анхны сурагчдыг бэлтгэж, Монгол нутагт энэ хөгжмийг сэргээж байна.

Тус ятга нь Солонгосын 13 чавхдаст гаяагум хэлбэртэй бөгөөд Монгол ятга нь нэг чавхдасаар эхэлсэн байх магадлалтай. Нум сумын дуу чимээ нь чавхдастай төстэй дуу чимээг үүсгэж, энгийн чавхдастай байснаа, дараа нь хоёр чавхдастай болж, улмаар 13 чавхдастай болжээ. Орчин үед ятгачид ихэвчлэн Хятадын 21 чавхдаст ятгыг гол хөгжмийн зэмсэг болгон ашигладаг. Ятга нь босоо ятга, хэвтээ ятга гэж ангилагддаг. Сүүлийн жилүүдэд Алтайн ятга олдсоноор Монгол ятгын өвөг гэж үзэх боломжтой. Өвөр Монголд Шилийнол мужийн Жамус багшаас суралцсан хүмүүс болон амьд байгаа Хүчит багшийн ятга нь өвөрмөц хэлбэр, загвартай бөгөөд Монгол ятгын өвөг гэж үздэг. Мөн Нарангэрэл багшийн сургуульд суралцсан хүмүүсийн Монгол ятга нь өөрийн өвөрмөц онцлогтой.

Монгол ятгын хөгжил нь цаг хугацааны явцад улам урагшилж байгаа бөгөөд Өвөр Монголын Монгол ятга нь хэрэглэгдэж байгаа хэдий ч хөгжих орон зай багатай, өргөн цар хүрээтэй хөгжих боломжгүй. Учир нь хөгжмийн зэмсгийн хөгжил нь хэд хэдэн үе шаттай байдаг. Нэгдүгээрт, хөгжмийн зэмсэг байх ёстой; хоёрдугаарт, холбогдох сурах бичиг эсвэл ая байх ёстой; гуравдугаарт, өргөн хүрээний үзэгчид болон энэ хөгжмийн зэмсгийг сурч, хөгжүүлэхийг хүссэн хүмүүс байх ёстой; дөрөвдүгээрт, шинэ бүтээлүүд хэрэгтэй бөгөөд цаг үеийн хөгжилтэй хослуулан хөгжих ёстой. Иймээс Монгол Улсын Монгол ятга нь хөгжихөд илүү тохиромжтой бөгөөд системтэйгээр чадварлаг хүмүүсийг тасралтгүй бэлтгэх боломжтой. Хэрэв цаг үеийн урсгалд орхигдвол хөгжиж чадахгүй болно. Тиймээс Монгол ятгын хөгжил нь хүн бүрийн чармайлт, өв уламжлалтай салшгүй холбоотой.

Хоёр. Монгол ятгын гоо зүйн онцлог: Монгол ятга нь онцгой өнгө аяс, өвөрмөц тоглох техникээрээ сэтгэл татам байдлыг илэрхийлдэг. Ятгын аялгуу нь тод, гүнзгий бөгөөд өргөн хүрээний сэтгэлийн өнгө аясыг дамжуулан илэрхийлэх чадвартай. Түүний тоглох арга барил нь нарийн бөгөөд зөвхөн уламжлалт техникээр хязгаарлагдахгүй, орчин үеийн шинэчилсэн арга барилуудтай хослуулсан байдаг. Энэ нь ятгын хөгжмийн олон талт байдал, урлагийн гүн гүнзгий шинж чанарыг бий болгодог.

Философийн үүднээс авч үзвэл, Аристотелийн “урлагийн зорилго нь дотоод утгыг илэрхийлэх бөгөөд гаднах хэлбэр нь хоёрдогч ач холбогдолтой” гэсэн үзэл санаа нь ятгын хөгжмийн гоо зүйн мөн чанарыг бүрэн тайлбарлаж чадна.

Пифагор эртний Грект анх удаа хөгжмийн “цэвэрлэх” (catharsis) нөлөөний талаар онол дэвшүүлсэн бөгөөд тэрээр хөгжим нь үйлдэл, дуу хоолойгоор дамжуулан хүний сэтгэлийг илэрхийлэх, өдөөх, нөлөөлөх хүчтэй гэж үзсэн (Ин Ай Чин, 2004: 8).

